

Магистр Т.Энхтунгалаг

МУИС-ийн Философиийн тэнхмийн багш

ОРЧИН ҮЕИЙН ХЭЛНИЙ ФИЛОСОФИ ДАХЬ УТГА (MEANING)-ЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Түлхүүр үг: утга, утга санаа (*sense*), бутцийн лингвистик, логик семантик, синтаксис, семантик, прагматик, семантик холизм, хэлэхүйн үйлдэл (*speech act*).

ХХ зууны 40-өөд он гэхэд хэл шинжлэлийн философиid хоёр гол хандлага ноёрхох болсон юм. Эдгээрийн нэг нь Ф.Д.Сюссор, Блумфильд нарын боловсруулсан бутцийн лингвистик, нөгөө нь Г.Фреге, Б.Рассел нарын бий болгосон логик семантик юм. Энэ үед бутцийн лингвистик нь утгын тухай асуудлыг төрөлх хэлний синтаксис бүтэц талаас нь түлхүү судалж байсан бол логик семантикт Г.Фреге, Б.Рассел, Р.Карнап гэх мэт аналитик философиийн төлөөлөгчид логикийн хувьд зөрчилгүй, нарийн чанд хэл зохиох зорилго тавиад энэ зорилгынхoo үүднээс “үнэн”, “денотат”, “оршихуй”, “утга”, зэрэг ойлголтуудыг боловсруулж байлаа.

Ф.Сюссор хэлийг бутцийн үүднээс судлах явцдаа хэл шинжлэлд бүтэцчлэх аргыг хэрэглэсэн нь структурализм үүсэх үндэс болсон байна. Структурализмын хөгжлийн үүслийн үе гэгддэг ХХ зууны 20-50 онуудад лингвистик структурализмд хэлийг судлахдаа түүний газарзүйн, нийгмийн, түүхэн гэх мэт нөхцөл байдал, хөгжлийнх нь төвшинг аль болох хийсвэрлэж, хэлний цэвэр бутцийг тодорхойлохыг эрмэлзэг байв. Иймээс Ф.Сюссор хэлийг формаль талаас нь өөрөөр хэлбэл диахрони /динамик/ гэхээсээ синхрони /статик/ гэж тодорхойлогдохуйц тэмдгийн систем болох талаас нь судалжээ. Энэ байрь суурины үүднээс аливаа тэмдэг нь тэмдэглэгч, тэмдэглэгдэгч хоёроос тогтоно. Иймд жишээ нь а, л, и, м гэсэн үсэгнүүдээс тогтсон үг нэгэн төрлийн жимсний, тодруулбал алимны ойлголтыг бидэнд төрүүлж байдаг.

Ф.Сюссорын үзсэнээр тэмдэглэгч, тэмдэглэгдэгч хоёрын хоорондын харилцаа нь дор хаяж хоёр үндэслэлээр тохиолдлын шинжтэй. Нэгд, сая дурдсан эдгээр үсэгний нийлбэр яагаад алим гэсэн объектыг юмуу ойлголтыг

тэмдэглэх ёстой вэ гэдэгт зайлшгүй шалтгаан байхгүй. Хоёрт, "алим" гэдэг уг тухайн "алим" гэсэн объекттой огт адилгүй. Ингэхлээр тэмдэглэгч, тэмдэглэгдэгчийн хоорондын холбоо конвенциаль шинжтэй аж. Гэхдээ алим гэдэг уг алимын тухай ойлголтыг юмуу энэ объектыг тэмдэглэхийн тулд л бий болсон учраас хэн ч энэ харилцааг дур зоргоороо өөрчилж чаддаггүй. Өөрөөр хэлбэл энэ харилцаа зарим утгаар /үүсэл гарвалын хувьд/ тохиолдлын шинжтэй ч зарим утгаар /хэрэглээний тухайд/ тийм биш гэж Сюссор үзсэн байна. Цаашлаад Сюссор тэмдэг /эн нь тэмдэглэгч, тэмдэглэгдэгчын хослол/ өөрөө ч тохиолдлын шинжтэйг онцолсон. Тэмдэг өөрөө болон түүний зааж буй зүйл /референт, өөрөөр хэлбэл жимс буюу физик объект/ хоорондын холбоо ч мөн тохиолдлын шинжтэй.

Гэвч зарим судлаач Сюссорын ярьж буйд эсрэгээр тухайн ойлголт шууд ба шууд бусаар бодит объекттой холбоотой үүсдэг, бодит алимын шинж тэмдэгүүд алимын тухай ойлголттой шалтгаант байдлаар холбогдоно гэж үздэг ч үнэндээ Ф.Сюссор хэлний хэрэглээнд биш, харин бүтцэнд анхаарлаа хандуулсан гэдгийг онцлох хэрэгтэй. Ийм ч учраас "структурализм" гэдэг нэр томьёо гарсан байна. Тэмдгийн хамаарах бодит юмыг судлах судалгааг хойш тавьж, оюун ухаанд төсөөлөгдөж буй зүйлийг л судлах зорилт тавьсан гэдэг утгаараа Сюссорын лингвистик структурализмыг Э.Гуссерлийн цэвэр феноменийн тухай үзэлтэй төсөөтэй гэж зарим судлаач үздэг. Утгын тухай асуудлаархи Ф.Сюссорын үндсэн санаа нь уг дангаараа байхдаа утга илэрхийлдэггүй харин өгүүлбэрт /өөрөөр хэлбэл бүтцэд/ орж байж, бусдаас ялгаран гүйцэтгэж буй үүргээсээ утгаа олдог гэдэгт оршино. Аливаа тэмдгийн системийн тэмдэг бүр нь бусдаас ялгарах бүтцийнхээ ачаар л утгатай байдаг аж. Өөрөөр хэлбэл "алим" гэдэг уг дангаараа буюу өгүүлэгчийн оюун санаанд утгатай байдаггүй. Харин боломжит бусад бүтцээс, жишээ нь н,а,в,ч, л,и,й,р зэргээс бүтсэн навч, лийр зэрэг бүтцээс ялгарч байгаа учраас л эдгээрээс ялгаатай утгыг авдаг гэж үзэж байна. Ингэхлээр структурализмын хувьд утга нь системийн /хэлний/ доторх элементүүд /тэмдэгүүд/ хоорондын ялгаанаас үүсдэг гэж ойлгож болно.

Ф.Сюссор утгын асуудлыг ийнхүү дан бүтцийн талаас нь тайлбарласан бол логик позитивизмын төлөөлөгчид түүнийг референт, денотант, утга санаа (sense) зэрэг ойлголтуудтай холбож тайлбарласан.

Хэлний илэрхийллийн утгын асуудлыг логикийн үүднээс нухацтай авч үзсэн хүн бол логикч, математикч Г.Фреге юм. Тэрээр "Утга ба утга санааны тухай /On meaning and sense/" гэсэн бүтээлдээ юуны өмнө нэрийн утга /meaning/ ба утга санаа /sense/ хэмээх ойлголтуудын ялгааг гаргасан байна. Ингээд Фреге "нэр" гэсэн ойлголтод юмыг шууд заагч жинхэнэ нэр төдийгүй, объектыг дүрслэн илэрхийлэгч дескрипциүүд, өгүүлбэрүүдийг ч хамааруулан ойлгож байлаа. Өгүүлбэрийн утга нь түүний үнэний утга /1 юмуу 0/, утга санаа нь тухайн өгүүлбэрийн гол агуулга гэж мөн үзсэн байна.

Фрегегийнхээр нэр болж буй хэлний илэрхийлэл бүрт утга санаа болон номинатыг ялгаж болох аж. Нэр нь аль нэг объектыг заадаг ба үүнийг нэрийн номинат гэнэ. Мөн нэр тодорхой утга санааг илэрхийлдэг. Утга санаа нь тухайн номинатын шинж тэмдгийг илэрхийлсэн хийсвэр агуулга бөгөөд номинатыг заах, түүнтэй нэрийг холбох хэрэгсэл болдог байна. Иймээс Фреге аливаа номинатын тухай мэдлэгийг бид түүнийг дамжуулах ямар нэг тодорхой утга санаагүйгээр мэдэж боломжгүй гэж үзсэн. Жишээлбэл, хэрвээ хэн нэгэн хүн "Цолмон" гаригийг мэддэг бол тэр үүнийг "Цолмон гариг бол үүрийн цолмон", "Цолмон гариг бол үдшийн гялаан" гэсэн бодомжуудаар л мэддэг. Өөрөөр хэлбэл тухайн илэрхийллийн утга болж буй номинат, референтийг бид тодорхой аргаар л танин мэдэх бөгөөд энэ нь тухайн илэрхийллийн утга санаа байдаг хэмээн тэрээр үзжээ.

Ийнхүү утгыг тухайн илэрхийллээр нэрлэгдэж буй объект, утга санааг тухайн объектыг нэрлэх янз бүрийн хэв маягууд гэж ойлгох ойлголтыг утгын тухай позитивист онол гэж зарим судлаачид нэрлэдэг ба энэ онол ёсоор нэг утгатай боловч ялгаатай утга санаа бүхий ойлголтууд байж болдог байна.

Утгын асуудлыг логик позитивизмын үүднээс гүнзгийрүүлэн судалсан өөр нэг философич бол А.Ж.Аейр юм. Тэрээр "Хэл, үнэн ба логик" зохиолдоо эмпирик шинжлэх ухааны хэл бол үнэн юмуу худал гэсэн утгыг авч болох цорын ганц хэл юм гэжээ. А.Ж.Аейрийн үзлээр хэлний илэрхийллийн утга бол түүний хэрэглээг "шалгахын" /verify/ тулд авч буй зүйл юм. Хэлний илэрхийлэл ядахдаа зарчмын хувьд шалгагдах боломжгүй бол утгагүй гэж үзжээ. Тодруулбал хатуу верификацын шалгуурт орох явдал тухайн илэрхийллийн утгатай байхын гол шалгуур болно гэсэн уг юм.

Хэлийт хэрэглэгчийн хүчин зүйлээс гадуур хэлний семантик асуудлыг авч үзэх боломжгүй гэж зарим судлаачид үздэг ч логик позитивизмийн

төлөөлөгчдөд нэг нийтлэг онцлог байгаа нь хэлийг судлахдаа түүнийг сэтгэл зүйн болоод бусад хүчин зүйлээс нь аль болох тусгаарлахыг эрмэлзэдэг явдал юм. Тухайлбал Рассел “үг өөрөөсөө өөр ямар нэг зүйлийг төлөөлж байдаг гэсэн хамгийн энгийн утгаараа утгатай гэж ойлгох нь логикт тохиромжтой” гэжээ. Үүнтэй холбоотой Рассел “мэдэж байна”, “итгэж байна”, “үзэж байна” гэх мэт илэрхийллүүд нь психологи элемент агуулсан, логикт тохиромжгүй гээд эдгээрийг пропозициональ хандлага /propositional attitude/ гэж нэрлэсэн. Ингээд Рассел психологизмаас зайлсхийхийн тулд утгын тухай асуудлыг эдгээр пропозициональ хандлагуудаас салангид авч үздэг. Хэн үг, өгүүлбэрийг ярьж байна вэ? хэнд хандаж хэлж байна вэ? гэдгийг Рассел тооцож үздэггүй. Гэвч пропозициональ хандлагууд нь утгын асуудалтай заавал холбогдоно гэдгийг өнөөдөр аналитик философичид өөрсдөө ч хүлээн зөвшөөрөх хандлагатай байна. Тухайлбал: аналитик уламжлалыг баримтлагч У.В.О.Куайн, Г.Н.Гудмен, М.Уайт нар утгын асуудлыг хэлний прагматик аспектад хандахгүйгээр шийдэх боломжгүй гэж үздэг юм.

Бүтцийн хэл шинжлэл, логик семанти克 хоёрт зарим нийтлэг дутагдал байдаг тухай судлаачид өгүүлдэг билээ. Тухайлбал: өдөр дутмын амьдралаас хол тасархай, хэлний үүсэл, мөн чанар, үйлчлэлийн механизмыг судлах үндсэн зорилгоосоо хөндийрөх тал гаргадаг, хэт бие даасан шинжтэй байдаг зэргийг дурддаг юм. Энэ байдлыг засварлах үүднээс ХХ зууны 60, 70-аад оны үед хэлийг судлахдаа хэлний семанти克 болон прагматик талуудыг тус тусад нь биш, харин хамтад нь бүхэллэг байдлаар судлах ёстой гэсэн үзэл санаа гарч ирсэн байна.

Энэхүү “прагматик эргэлтэд” хожуу үеийн Л.Витгенштейн(1889-1951)-ий үзэл санаа чухал нөлөө үзүүлжээ. Ер нь хэл шинжлэлийн философиid өнөө ноёлж буй хандлагын эх суурийг Л.Витгенштейн тавьсан гэж судлаачид үздэг. Үг нь логик позитивистуудын үзлийг хамгийн тохиромжтой байдлаар илэрхийлсэн мэт позитивистуудад санагдаж байсан бүтээл бол Витгеншнейний “Логик-Философиин шаштир” (*Tractatus Logico-Philosophicus*) юм. Тэрээр энэ бүтээлдээ хэл ба бодит байдалд хандах аналитик уламжлалыг баримталж үг бол ямар нэг баримтыг төлөөлж байгаа учраас л утгатай байдаг гэж үзэж байсан. Гэвч тун удалгүй 1920-иод оны сүүлээр анхны үзэл санаагаа хянан үзсэнээр, хэлний априори бүтцийг илрүүлэх,

логикийн хувьд төгс хэл бүтээх, баримтат өгүүлбэрүүдийг феноменологи хэл рүү хөрвүүлэх зэрэг зорилтуудаасаа татгалзсан байна.

Ийнхүү Витгенштейн логик семантикт хамаарах эрэл хайгуулаа орхиж, төрөлх хэлийг байгаа байдлаар нь судлах болсон нь хожим зөвхөн түүний үзэл санааны хувьд биш, ерөөс хэлний философиид гарсан өөрчлөлтийн үндэс болжээ.

“Хожуу” үеийн Витгенштейний гол зохиол нь “Философиин судалгаа/Philosophical Investigation/” юм. Тэрбээр энэ зохиолдоо ердийн хэлний илэрхийллийн утга бол түүний хэрэглээ мөн гэсэн концепцийг гаргасан нь хэлний pragmatикийн чиглэлээрх орчин үеийн судалгаанд чухал нөлөө үзүүлсэн. Витгенштейний хувьд үгийн утга бол түүний зааж буй бодит юм (референт) биш, мөн бидний ухамсарт буй санаалаг (ментал) дүр ч биш юм. Өөрөөр хэлбэл утгат чанарын асуудлыг референциализм, ментализмын үүднээс тайлбарлах тайлбарт аль алинд нь шүүмжлэлтэй хандсан байна.

Үгийн утга бол түүний хэрэглээгээр тодорхойлогдоно гэсэн Витгенштейн нарын үзэл ёсоор хэлний утгын асуудлыг судлахдаа хэлэнд зөвхөн өөрт нь, эсвэл хэлээр ярьж буй хүнд л анхаарал тавих бус, түүнийг тодорхой нийгэм, соёлын болон хэрэглээний контекстэд судлах ёстой юм. Утга бол хэлэнд өөрт нь байdag зүйл биш. Учир нь, хэлний тэмдэгүүдийн хоорондын формаль холбоо дангаараа ямар нэг утгатай байх боломжгүй. Нөгөө талаас утга тухайн хүний “хувийнх” байх боломжгүй гэж үзсэн.

Үг нь тодорхой контекстэд /хэлний тоглоомд/, холбогдох дүрмийн дагуу хэрэглэгдсэнээр утгатай болдог гэж лингвистик философичид үздэг. Гэхдээ контекст бүрд үгийн утгат чанар ижил байх албагүй ажээ.

Үгийн утга бол түүний хэрэглээ гэж тодорхойлсонтойгоо холбоотойгоор Л.Витгенштейн “хэлний тоглоом”, “амьдралын хэлбэр” зэрэг ойлголтуудыг лингвистик философиид оруулж ирсэн юм. Бодит байдал дээр ялгаатай бүтэц бүхий байж, өөр өөр хэрэгцээг хангах олон хэл орших ба аливаа хэл хатуу тогтсон логик бүтэцгүй, харин олон дэд бүтцүүдийн, өөрөөр хэлбэл хэлний тоглоомуудыг агуулж байdag гэж тэрээр үзжээ.

Л.Витгенштейн хэлний тоглоомын нийгэм соёлын талыг “амьдралын хэлбэр” хэмээх ойлголтоор гаргасан ба хүний үйлдэл, үйл ажиллагаанд лингвистик болон лингвистик биш үйлдлүүд харилцан сүлжилдсэн байdag гэсэн санааг энэ ойлголтоор илэрхийлжээ.

Утгын тухай ийм санаа нь семантик холизмтай нягт холбогддог. Семантик холизм нь репрезентацийн явцад тэмдгийн утга нь тухайн тэмдгийг өөрийг нь агуулж буй бүхэл бүтэн репрезентацийн системтэй холбоотой гэсэн санааг илэрхийлдэг ойлголт юм. Энэ үүднээс хандвал хэлний илэрхийлэл нь зөвхөн хэлний контекстийн хүрээнд л утгатай аж. Орчин үеийн семантик холизмын төлөөлөгчид нь Д.Дэвидсон, У.В.О.Куайн, Д.Гильберт, В.Харман, Ж.Сийрл нар болно.

Хэлний илэрхийллийн утга бол түүний хэрэглээгээр тодорхойлогдоно гэсэн санааг орчин үед хоёр үндсэн чиглэлээр хөгжүүлж байна. Үүнд: Дж.Остин, П.Стросон, Н.Малcolm нар ердийн, ярианы хэлний зарим илэрхийллийн хэрэглээг, жишээ нь: "би мэднэ" гэсэн илэрхийллийн хэрэглэгдэх байдлыг шинжилсэн бол Ж.Сийрл, Грайс нар тухайн хэлний илэрхийлэлд биш, харин хэлний хэрэглээний контекст гэсэн ойлголтод анхаарлаа хандуулсан. Энд "контекст" гэсэн ойлголт хэлний ба хэлний биш, нийгэм-соёлын, сэтгэл зүйн гэх мэт олон талаас гадна тухайн хүний мэдлэгийг, цаашлаад яригчийн танин мэдэхүйн буюу когнитив төлөвийг ч хамардаг. Бодит байдал дээр хэлийг танин мэдэхүйн болоод амьдралын янз бүрийн туршлагатай, тэр ч бүү хэл хувийн санаа бодол, зорилго, хүсэл эрмэлзэл, хэрэгцээ, хэм хэмжээ, итгэл үнэмшил зэргээрээ ялгаатай хүмүүс **хэрэглэдэг** гэсэн санааг энэхүү "контекст" хэмээх ойлголт бас илэрхийлдэг байна. Иймээс орчин үед хэлний философи судалгааг когнитив психологи, зохиомол оюуны онол, эпистемологи зэрэг мэдлэгийн салбаруудын уулзвар дээр явуулж байна. Ийм интердисциплинар судалгааны нэг жишээ бол Ж.Сийрлийн бичсэн "Интенциональ төлөв" гэдэг зохиол юм.

Ж.Сийрл "интенциональ төлөв" гэсэн ойлголтыг философиинхoo үндсэн ойлголт болгож оруулсан. Энэ нь субъектээс бодит байдал руу чиглэсэн чиглэлт байдал юм. Анхдагч интенциональ төлөвийн тоо маш олон байж болох боловч интенциональ төлөвийн тусламжтайгаар ертөнцтэй өөрсдийгээ харьцуулах хүн төрөлхтний чадвар маань бидэнд хэл бий болохоос өмнө бий болсон зүйл. Энэ нь ярьдаггүй, хэлэхүйн үйлдлийг хийх чадваргүй амьтанд ч интенциональ төлөв бий гэсэн үг. Харин хэл бол анхдагч интенциональ хэлбэрүүдийн илүү хөгжингүй онцгой хэлбэр нь юм.

Энэ утгаараа хэлний философи бол ухамсын философиин нэг бүрэлдхүүн аж. Иймээс утга, утга санаа гэх мэт суурь семантик ойлголтуудыг

“итгэл үнэмшил”, “хүсэл”, “интенци” зэрэг илүү суурь ойлголтуудын тусламжтайгаар шинжлэх бүрэн үндэстэй гэж Сийрл үзжээ.

Харин Г.Фрегегийн референцийн онол болон Л.Витгенштейны хэрэглээний онолыг нэгтгэх оролдлогыг М.Даммит хийсэн байна. Ердийн хэлний хүрээнд аливаа илэрхийллийг тодорхой хэлэхүйн үйлдлийн (speech act) контекстэд авч үзэх хэрэгтэй. Учир нь, илэрхийллийн утгат чанарыг тодорхойлоход өгүүлбэрийн үнэний нөхцөл болон түүнийг хэлэх үед хийгдэж байгаа үйлдэл үйлдлийн шинж төрх хамгаас чухал ажээ.

Утгын онол нь хэлний семантик мэдлэг ба хэлийг ашиглах чадвар хоорондын харилцааг тогтоож чадсан тохиолдолд л зохистой гэж М.Даммит үздэг. Иймээс семантик мэдлэг хэлийг хэрэглэх үед ажиглагдаж буй яригчийн төрх байдал нь өөрөө семантик мэдлэг үүсэх анхдагч цэгүүдийн нэг болж өгдөг ажээ. Энэ утгаараа Даммитын үзэл баримтлал бүрэн ойлгомжтой, үндэслэгээтэй юм.

Ийнхүү дээр өгүүлсэнүүдээс дүгнэн үзвэл орчин үед хэлийг философи үүднээс тайлбарлахдаа ухамсын философитой холбон авч үзэх явдал нийтлэг болсон ба энэ нь хэл нь ухамсын илэрхийлэл болдог гэдэг утгаараа биш, харин хэл өөрөө ухамсыг төлөвшүүлдэг гэсэн санаанд голдуу үндэслэж байгаа юм. Мөн хэлний илэрхийллийн утга ба утга холбогдлын асуудлыг янз бүрийн философиid олон талаас нь авч үзээд ялгаатай тайлбаруудыг өгч байгаа нь эдгээр ойлголтууд өөрөө нэлээд нарийн нийлмэл, олон талтай болохыг илтгэж байна.

At the first half of the XX century, two main approaches dominated in linguistic philosophy. These approaches are structural linguistics and logic semantics. According to structural linguistics, words have no meaning in themselves, but they get their meaning from the difference in language system. From the point of logical view, G.Frege considers that meaning is different from sense of word. Meaning is what a word refers to, sense is a mode to express the meaning of the word.

However, the author agrees with an opinion that the contemporary theory of meaning is based on later L.Wittgensstein's view. In his theory, the meaning of a word is determined by its usage. Today the use theory of meaning is developed by J.Searle, W.V.O.Quine, D.Davidson, D.Hilbert, B.Harman, M.Dammett etc.